

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 13.030.01

Байгаль орчин. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, код	MNS 6501 : 2015
Environment. Classification and code of wastes from leather and fur tanning	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь арьс, шир болон үслэг боловсруулах үйлдвэрлэлээс гарах бүх төрлийн хаягдлын ангилал, кодчиллын хүрээг хамарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах иш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан ишлэлийн хувьд зөвхөн иш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй ишлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлт өөрчлөлтийн хамт)–ийг хэрэглэнэ.

-2010/75/EU тогтоол. Үйлдвэрлэлийн хаягдлын удирдамж. Бохирдлоос урьдчилан сэргийлэлт ба хяналт (Industrial emissions directive 2010/75/EU. Integrated pollution prevention and control)

-MNS 4943-11 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага

-MNS 5582 : 2006 Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус

-MNS 5480 : 2005 Арьс, ширний технологи. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага

-MNS 4288 : 1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага

-MNS 3348 : 2003 Желатин, цавуу, малын уурагт тэжээлийн түүхий эд. Техникийн шаардлага

-MNS 5077 : 2001 Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын урсгалыг хэмжих арга

-MNS ISO 3342 : 1982 Усан мандал. Газар доорхи усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага

-Монгол улсын Дэд бүтцийн сайд, Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1997 оны а/11/05/А/18 тоот тушаал, “Бохир ус

MNS 6501 : 2015

зайлуулах төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх үйлдвэрийн бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээ”

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1

хаягдал

арьс, ширэн түүхий эдийн шинж чанарыг хими, физик-хими, механикийн аргаар өөрчилж боловсруулах явцад гарах хатуу, шингэн ба хийн төлөвт үлдэгдэл

3.2

хатуу хаягдал

арьс, ширэн түүхий эдэд хими, физик-химийн боловсруулалт хийх явцад механик аргаар салгасан цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй арьсны хэсэг, лаг болон өнгө заслын бодисын үлдэгдэл

3.2.1

идээлээгүй арьсны хаягдал

идээлэг хүртэлх механик дамжлагуудаас гарсан хром эсвэл бусад төрлийн идээлэгч бодис агуулаагүй нойтон болон нүцгэн арьсны зах, год, халим, шар мах, ашиглагдахгүй хуулдас

3.2.2

идээлсэн арьсны хаягдал

хром эсвэл бусад идээлэгч бодис агуулсан нойтон хөх арьс, шир болон гүйцэд боловсруулсан савхины зах, өөдөс, зоргодос

3.2.3

хром агуулаагүй лаг

идээлэг хүртэлх дамжлага ажиллагаануудад ашигласан шимээс тунасан хромын давс агуулаагүй, уусаагүй өтгөн үлдэгдэл

3.2.4

хром агуулсан лаг

хромын идээлэг, нэмэлт идээлэг дамжлагуудад ашигласан шимээс тунасан хромын давс агуулсан, уусаагүй өтгөн үлдэгдэл

3.2.5

өнгө заслын хаягдал

арьсыг хучиж будах, бэхжүүлэх дамжлага ажиллагаануудын үед арьсны гадуур цацагдсан будаг, холбогч, уусгагч, лак, бэхжүүлэгч, дүүргэгч зэрэг бодисын үлдэгдэл

3.2.6

тодорхойлогдоогүй бусад хаягдал

үйлдвэрлэлийн технологийн усны гаргалгааны шугамын хаалт, шүүлтүүрт үлдсэн үс, ноос, хөөвөр, өөх, тос, дэвтээлгийн дамжлагаас гарсан элдэв жин хүндрүүлэгч, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээний бодисын үлдэгдэл

3.2.7**дахин ашиглах хатуу хаягдал**

арьс, ширийг хуваах дамжлагаас гарсан хуулдас арьс

3.2.8**хоёрдогч түүхий эдээр ашиглах боломжтой хатуу хаягдал**

идээлээгүй буюу хром агуулаагүй арьсны хаягдал, зориулалтаар нь ашиглах боломжгүй хуулдас, лаг, үс, ноос, хялгас, зоргодос

3.2.9**аюултай хатуу хаягдал**

Тос авалт, идээлгээс гарсан хром, органик нэгдэл бүхий хатуу хаягдал

Тайлбар: Зөвхөн зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан концентраци бүхий бодис агуулсан хортой хаягдлыг аюултайд тооцно.

3.2.10**эргэлтгүй алдагдал**

хаягдлын ангилалд заасан тодорхойлогдоогүй бусад хаягдал, өнгө заслын хаягдал

3.3**шингэн хаягдал**

арьс, ширэн түүхий эдэд химийн боловсруулалт хийх явцад гарах органик ба органик бус химийн бодис болон уургийн задралын үлдэгдлээр бохирдсон ус

3.3.1**дэвтээлэг, шохойдлогын шим**

арьсыг дэвтээх, үс авах дамжлагаас гарсан уургийн задралын үлдэгдэл, органик болон органик бус бодис агуулсан шингэн

3.3.2**хром агуулсан идээлгийн ашигласан шим**

давс, хүчил, хром, тос, синтан идээлэгч, дүүргэгч агуулсан шингэн

3.3.3**хром агуулаагүй идээлгийн ашигласан шим**

ургамал, хөнгөн цагаан, альдегид болон бусад идээлэгч бодис, дүүргэгч, тос агуулсан шингэн

3.3.4**дахин ашиглах шингэн хаягдал**

уусмалын концентрацийг регенераци, рециркуляци хийх замаар дахин ашиглах боломжтой шохойдлого, нэвтэлгээ, тос авалт болон идээлгийн ашигласан шим

3.3.5**цэвэрлэх байгууламжинд цэвэршүүлэх шингэн хаягдал**

арьс ширийг химийн ба механик аргаар боловсруулах дамжлага ажиллагаануудаас гарах хуучирсан шим болон шавхарга

3.4

хийн хаягдал

арьс, шир болон үслэг боловсруулах үйлдвэрийн технологийн дамжлага ажиллагаануудаас гарах химийн бодисын хийн ялгарал

4 Хаягдлын ангилал

4.1 Төлөв байдлаар нь:

- хатуу хаягдал
- шингэн хаягдал
- хийн хаягдал

4.2 Боловсруулалтын байдлаар нь:

4.2.1 Хатуу хаягдлыг:

- идээлсэн арьсны хаягдал
- идээлээгүй арьсны хаягдал
- хром агуулсан лаг
- хром агуулаагүй лаг
- өнгө заслын хаягдал
- тодорхойлогдоогүй бусад хатуу хаягдал гэж ангилна.

4.2.2 Шингэн хаягдлыг:

- Дэвтээлэг, шохойдлогын ашигласан шим
- Хром агуулсан идээлгийн ашигласан шим
- Хром агуулаагүй идээлгийн ашигласан шим

4.3 Ашиглалтын байдлаар нь:

4.3.1 Хатуу хаягдлыг:

- дахин ашиглах боломжтой
- хоёрдогч түүхий эдээр ашиглах боломжтой
- эргэлтгүй алдагдал

4.3.2 Шингэн хаягдлыг:

- дахин ашиглах
- цэвэрлэх байгууламжинд цэвэршүүлэх гэж тус тус ангилна.

5 Хаягдлын код

1-р хүснэгт - Хаягдлын ангиллын код

Хаягдлын код	Хаягдлын ангилал
04 01	Арьс, шир болон үслэг боловсруулах үйлдвэрлэлийн хаягдал
04 01 01	Идээлээгүй хатуу хаягдал. Годолгоо, махалгаа ба халимлагаанаас гарах арьсны зах, год, халим, өөх, шохойтой хуулдас зэрэг хаягдал
04 01 02	Шохойдлогын шим
04 01 03 ^(a)	Тос авалт, идээлгээс гарсан органик уусгагч агуулсан хаягдал
04 01 04	Хром агуулсан идээлгийн ашигласан шим
04 01 05	Хром агуулаагүй идээлгийн ашигласан шим
04 01 06	Хром агуулсан лаг
04 01 07	Хром агуулаагүй лаг
04 01 08	Идээлсэн хатуу хаягдал. Боловсруулсан арьсны хаягдал (хусахын зоргодос, захалгааны өөдөс, зүлгэхийн үртэс)
04 01 09	Өнгө заслын хаягдал
04 01 99	Тодорхойлогдоогүй бусад хаягдал
^(a) Аюултай хаягдал (Council Directive) 91/689/EEC	

6 Хаягдалд тавигдах шаардлага

6.1 Идээлээгүй буюу хром агуулаагүй хатуу хаягдал нь MNS 3348 “Желатин, цавуу, малын уурагт тэжээлийн түүхий эд” стандартын шаардлага хангасан байна.

6.2 Идээлсэн хатуу хаягдлыг заавал урьдчилан фермент эсвэл химийн аргаар задлаж, ялгасан хромыг идээлгэнд, харин уураг агуулсан үлдэгдлийг хоёрдогч түүхий эдээр тус тус дахин ашиглаж болно.

6.3 Хром агуулсан лагийг заавал урьдчилан химийн болон биологийн аргаар саармагжуулалт хийх ба саармагжуулсан лагийг 10%-15% хүртэл чийгтэй байхаар усгүйжүүлж, зөвшөөрөгдсөн хогийн байгууламжинд булна.

6.4 Хром агуулаагүй лагийг ХАА, аж үйлдвэр, барилга, эрчим хүчний салбарт төрөл бүрийн уураг агуулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үндсэн ба туслах түүхий эд болгон ашиглаж болно.

6.5 Шингэн хаягдал нь MNS 5582 “Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус” стандартын шаардлага хангасан байна.

6.6 Хийн хаягдал нь хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөргүй хэмжээний ажлын байрны агааржуулалттай байна.

ТӨГСӨВ.